

Golomt Capital®

# Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.04.04

*Дотоодын зах зээл  
Олон улсын зах зээл*

## ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 4 сарын 4


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	2,970.93	1.615%	4.267%	4.255%

## Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 1.61 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах үүднээс 2022.03.24-нд бодлогын хүүг 6.5 хувиас 9 хувь болгож 2.5 нэгжээр нэмсэн бөгөөд тээвэрлэлтийн саатлыг зогсоосон тохиолдолд ханш тогтворжих боломжтой.

## Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 177.1 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкнуудын 3 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах саналыг биелүүлсэнгүй.



## Ханшид нөлөөлөхүйц үйл явдал, суурь үзүүлэлтүүд:

- 2022.3.24-нд Монголбанкнаас бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9.0 нэгж хувьд хүргэлээ. Олон улсын нөхцөл байдал шокийн шинжтэй нөлөө үзүүлж байгаа нь эрчимтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн байна. Бодлогын хүү өссөнөөр эрэлтийн гаралтай инфляцын хэмжээ буурах цаашилбал тухайн орны валютын ханш тогтвортой байх суурь нөхцөлийг бүрдүүлдэг.
- 2022.4.01-ээс эхлэн Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтоор нүүрс тээвэрлэгч автомашины тоо 300 болсон нь гадаад худалдааны тэнцэлд эерэгээр нөлөөлж буй ч хэвийн үед 1000-2000 автомашин гардаг байсан үетэй харьцуулахад хангалтгүй байгаа юм.
- Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022.2 сарын байдлаар 3.6 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 18.35 хувиар буурав. Хэрэв тээвэр ложистикийн асуудлыг шийдэж валютын орох урсгалыг нэмэгдүүлэхгүй бол ханшийн сулрал үргэлжилсэн хэвээр байх эрсдэлтэй байна.


**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ДОТООД ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Гадаад валютын албан нөөц:

Монгол Улсын гадаад валютын албан нөөц сүүлийн 5 жил тасралтгүй өссөөр 2021 оны 4 сард түүхэн дээд буюу 4.9 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2021 оны 11 дүгээр сард 4.2 тэрбумд хүрч буурсан ба уналтын трэнд үргэлжилсээр 3.6 тэрбум ам.долларт хүрлээ. ГВАН 3.6 тэрбум ам.доллар болж буураад байна.


График 1: Гадаад валютын албан нөөц (сая ам.доллар)



## Гадаад худалдаа:

2022 оны эхний 2 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдаа 125.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Тайлант хугацаанд нийт бараа эргэлт 5.5 тэрбум ам.доллар байгаагаас экспорт 1.6 тэрбум ам.доллар, импорт 1.5 тэрбум ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг.

График 2: Гадаад худалдаа (сая ам.доллар)



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 4 сарын 4

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	98.58	-0.06%	0.26%	-2.09%
EURUSD	1.1049	0.65%	1.13%	-6.45%
USDCNY	6.3622	-0.13%	0.70%	-3.07%
USDRUB	83.95	-6.46%	-34.49%	9.90%
USDJPY	122.55	-1.08%	6.79%	11.26%
AUDUSD	0.7509	0.29%	1.89%	-1.83%

## DXY ханшийн хөдөлгөөн

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн сулрах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд доорх хүчин зүйлс нөлөөлөв.

- АНУ-ын Nonfarm Payroll буюу ХАА-н бусад салбарын ажил эрхлэлтийн мэдээллээр 431,000 шинэ ажлын шинээр байр үүссэн нь өмнөх сарын 750,000 шинэ ажлын байрнаас багассан үзүүлэлт юм.
- Японы төв банк иенийн ханш 2015 оны 11 сарын сулралын түвшинд очсонтой холбоотойгоор ханшийг тогтворжуулах үүднээс интервенцийг нэмэгдүүлэхээ мэдэгдсэнээр ам.долларын эсрэг чангарсан байна.

## Энэ 7 хоногт хүлээгдэж буй онцлох үйл явдлууд

- 4 сарын 5-нд Монголын цагаар 20 цаг 30 минутад АНУ-ын гадаад худалдааны тоон мэдээлэл гарна.
- 4 сарын 7-нд АНУ-ын шинээр ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоон мэдээлэл гарна.

## График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 4Apr2022 - 5:36:13 GMT. Powered by Tradingview  
US Dollar Index, United States, NYSE:DXY, W



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.